

Сурагчдын сэтгэн бодох чадамжийн түвшинг лабиринт дасгалын аргаар судалсан нь

Jun Xi,

Өвөр Монгол багшийн их сургууль

Хураангуй

Сурагчид лабиринт бодлогын хувьд тааруу гүйцэтгэсэн байгаа нь багшийн заах арга зүйтэй холбоотой хэмээн үзэж байна. Нөгөө талаас бага ангийн сурагчдын сэтгэн бодох чадварын төвшинтэй холбоотой. Судалгаанд хамрагдсан суралцагчдын 66 хувь нь даалгаврыг гүйцэтгэв. Шийдлийн санааг зөв олж тодорхойлон 63 суралцагчийн 18.5 хувь нь асуудлыг зөв бүрэн 46.2 хувь нь дутуу, 20.1 хувь нь буруу гүйцэтгэж, 6,9 хувь нь санаагаа шийдвэрлэн даалгаврыг гүйцэтгэж чадаагүй байна. Харин судалгаанд хамрагдсан нийт суралцагчдын 36 хувь нь лабиринт дасгал даалгаврын шийдлийн санааг олж чадаагүй байгаа нь сэтгэн бодох чадвар сул, лабиринт дасгал даалгавар хийж байгаагүй зэрэг олон нөхцөл шалтгаанаар нийт суралцагчдын 1\5 хувь нь дасгал даалгаврыг зөв гүйцэтгэсэн байна. Дүрслэх урлагийн хичээлээр сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх бодлого, дасгал, даалгаврыг гүйцэтгүүлэхдээ дагуулан дуурайлгах, хуулбарлан бүтээлгэх идэвхгүй хэлбэрээс аль болох зайлсхийж, дасгалын хөнгөн хүндийг зөв сонгон өгсөн эсэх асуудалтай холбоотой хэмээн судалгааны дүгнэлт хийсэн байна. 4 ангийн сурагчдын шинийг сэдэж шийдвэрлэх гүйцэтгэлийн түвшин 66 хувьтай байна. Судалгаанд өгсөн даалгаврын агуулга нь суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон, боловсролын агуулгатай уялдсан бүрэн гүйцэтгэх боломжтой болох нь харагдлаа.

Түлхүүр үг

Сэтгэн бодохуй, хийсвэр сэтгэлгээ, эрэл хайгуул, бүтээхүй, загвар, шийдэл

Удиртгал

Хүн бүр бага балчираасаа аливаа асуудлыг их, бага ямар нэг хэмжээгээр шийдвэрлэж байхыг амьдрал шаардаж байдаг. Асуудлыг шийдвэрлэх чадвартай болох нь хүний зайлшгүй хэрэгцээ шаардлага төдийгүй боловсрол эзэмших үндсэн хэрэгцээ болно. Бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлсэн хэн бүхэн шинийг сэдэж, шийдвэрлэх ирээдүйд сайхан амьдрахад нь дасан зохицох чадварыг эзэмшдэг байна.

Суралцагч сэтгэхүйн үйлдлүүдээр дамжуулан оюун ухаандаа дүр босгох нь шинийг сэдэх, харин түүнийгээ бодит болгон гүйцэтгэх нь шийдвэрлэж байгаа хэрэг юм. Жишээ нь, сурагчдад лабиринт дасгал хийх даалгавар өгөхөд бүтээлч сэтгэлгээ нь хурдан хөгжиж байгаа нь бидний судалгааны дүнгээс харагдаж байна. Дүрслэх урлагийн хичээлээр асуудлыг шийдэх, шинийг сэдэж, шийдвэрлэх зүй тогтолд тулгуурлах хэдий ч лабиринт дасгал хийлгэснээр даалгаврын шийдлийг тооцож, боловсруулан, зураг төсөл, макет, загвараар загварчлан биетээр үзүүлэх чадамжийг олж авдаг болно.

Судалгааны арга зүй

Дүрслэх урлагийн хичээлийн агуулгад

лабиринт дасгал даалгаврыг нэмж оруулан, туршилт явуулж, ЕБС-ийн бага ангид суралцагчдын шинийг сэдэж, шийдвэрлэх үйл ажиллагааг магадлан тодорхойлох судалгааг явууллаа. Судалгаагаар ЕБС-ийн 4-р ангийн сурагчдаар лабиринт дасгал даалгаврыг гүйцэтгүүлэв. Үүнд:

4-р ангийн сурагчдад лабиринт дасгал даалгаврыг гүйцэтгэх туршилт хийв. Энэ даалгавар нь хүүхдийн сэтгэн бодох үйлийн түвшин ямар байна, нөгөө талаар сэтгэн бодох чадварын хурд, сэтгэлгээний чадамжийг тодорхойлох практик үйлийн чадвар хир зэрэг байгааг тодруулах юм.

Судалгааны үр дүн


Судалгаанд Хөххотын 114, 78-р сургууль, Хараат дунд сургуулийн 4-р ангийн нийт 98 сурагч хамрагдлаа. Судалгааг явуулахдаа суралцагчдад даалгаврын зорилгыг танилцуулан хугацаа тогтоогоогүй болно. 4-р ангийн сурагчид даалгаврыг хэрхэн гүйцэтгэж, сэтгэн бодох чадвар нь ямар түвшинд байгаад доорх дүгнэлтийг хийлээ.

Хүснэгт 1. 4 ангийн суралцагчдын лабиринт дасгал даалгавар гүйцэтгэх, сэтгэн бодох чадварын түвшинг тодорхойлох судалгааны дүн

№	Сургуулийн нэр	Анги	Суралцагчдын тоо	Шийдлийн санааг зөв олсон	Гүйцэтгэлийн байдал				Шийдлийн санааг зөв олоогүй	Бодит сэтгэхүйд тулгуурлан бүтээсэн	Сонгосон зүйлээ хийж чадаагүй
					Бүрэн гүйцэтгэсэн	Дутуу гүйцэтгэсэн	Буруу гүйцэтгэсэн	Хийж чадаагүй			
1	114-р сургууль	4-7	37	23	7	6	6	1	10	6	2
2	Хараат дунд сургууль	4-6	26	22	11	7	5	1	10	6	5
3	78-р сургууль	4-3	35	19	2	16	2	2	14	9	5
4	Бүгд	3	98	64	20	29	13	4	34	21	12

Суралцагчид лабиринт дасгал даалгавар гүйцэтгэх ажиллагааг сонирхолтой бөгөөд идэвхтэй гүйцэтгэж байв. Нийт судалгаанд хамрагдсан суралцагчдын 80 гаруй хувь нь чин сэтгэлээсээ хандаж, дасгал даалгаврыг амжилттай гүйцэтгэхийг хичээн чармайж байв. Сурагчид лабиринт дасгал гүйцэтгэх сонирхолтой байгаа нь цаашид бага ангийн дүрслэх урлагийн хичээлийн хөтөлбөрт энэхүү дасгал даалгаврыг тусгах шаардлага байгааг харуулж байна. 4 ангийн суралцагчид лабиринт дасгал даалгаврыг гүйцэтгэсэн байдлыг хувиар тодорхойлж үзэхэд дараах үзүүлэлттэй байна (Диаграм 1).

Диаграм 1. 4 ангийн суралцагчдын лабиринт дасгал даалгавар гүйцэтгэсэн байдлын үзүүлэлт \ хувиар\



Судалгаанд хамрагдсан суралцагчдын 66 хувь нь даалгаврыг гүйцэтгэв. Шийдлийн санааг зөв олж тодорхойлон 63 суралцагчийн 18.5 хувь нь асуудлыг зөв бүрэн 46.2 хувь нь дутуу, 20.1 хувь нь буруу гүйцэтгэж, 6,9 хувь нь санаагаа шийдвэрлэн даалгаврыг гүйцэтгэж чадаагүй байна. Харин судалгаанд хамрагдсан нийт суралцагчдын 36 хувь нь лабиринт дасгал даалгаврын шийдлийн санааг олж чадаагүй байгаа нь сэтгэн бодох чадвар сул, лабиринт дасгал даалгавар хийж байгаагүй зэрэг олон нөхцөл шалтгаанаар нийт суралцагчдын 1\5 хувь нь дасгал даалгаврыг зөв гүйцэтгэсэн байна. Дүрслэх урлагийн хичээлээр сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх бодлого, дасгал, даалгаврыг гүйцэтгүүлэхдээ дагуулан дуурайлгах, хуулбарлан бүтээлгэх идэвхгүй хэлбэрээс аль болох зайлсхийж, дасгалын хөнгөн хүндийг зөв сонгон өгсөн эсэх асуудалтай холбоотой хэмээн үзэж байна.

Энэхүү судалгааны дараа сурагчдад лабиринт дасгал даалгавар гүйцэтгэх аргазүйг эзэмшүүлэх зорилгоор 1-5 сарын үйл ажиллагааг явуулсан болно.

Хүснэгт 2

№	Чадварууд ба суралцсан хугацаа	1-2 сар	1-3 сар	1-4 сар	1-5 сар	5 дээш сар	Нийт тоо	Хувь
1	Сэтгэн бодох чадвар дээшилсэн	40	45	31	21	26	163	14.6
2	Тоо бодох хурд дээшилсэн	60	62	38	24	30	214	19.1
3	Бүтээлч сэтгэлгээний хурд дээшилсэн	40	45	28	18	27	158	14.0
4	Ой тогтоолт сайн болсон	53	49	34	24	25	185	17.0
5	Хичээлдээ төвлөрөлт сайн болсон	60	33	26	23	23	165	14.8
6	Цээжээр боддог бодсон	40	46	33	25	26	170	15.6
7	Мэдэхгүй	44	21				65	4.9
8	Нийт тоо	337	297	190	135	157	1290	13.3

Хүснэгт доторх тоо судалгаанаас харахад эзэмшүүлэх сургалтын явцад хүүхдийн лабиринт дасгал даалгавар гүйцэтгэх чадвар гүйцэтгэлийн чадамж огцом өсч байснаа цаашдаа

чадвар болон төлөвшдөг гэсэн дүгнэлтийг хийж байна. Түүнчлэн судалгааны явцад лабиринт дасгал даалгавраар хичээллэсэн сурагчидтай ангид дүрслэх урлагийн нээлттэй хичээлийг зохион байгуулж багш нараас үнэлгээ дүгнэлт авч, хичээлийн судалгаа хийлгэсэн болно. Нийт 18 багш хамрагдав. Багш нар танилцуулах хичээлд суусны дараа:

Хүснэгт 3

№	Багш нарын тавьсан саналууд	Тоо
1	Богино хугацаанд маш үр дүнтэй сургасан байна	15
2	Сургалтын хэрэглэгдэхүүн гарын авлага байна уу	14
3	Лабиринт дасгал даалгаварын аргад суралцсаар байна.	16
4	Түгээн дэлгэрүүлэх ажлыг хийх хэрэгтэй	18
5	Багш нарт зориулсан сургалт явуулж болох уу	12

Хүснэгтээс харахад багш нар лабиринт дасгал даалгаврын аргаар сурагчдын сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх талаар сургалтад суухыг сонирхож байгаа төдийгүй энэхүү лабиринт дасгал даалгаврын аргазүйг эзэмшин сурагчдыг хөгжүүлэх хэрэгцээ байгаа нь энэхүү судалгаанаас харагдаж байна.

Туршилтын үр дүн

Дээрх судалгаанаас бид, бага ангийн сурагчдад дасгалын мөн чанарыг ойлгож ухаарахад нь зайлшгүй дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн суралцагчийн сурах үйлд гарч байгаа хүндрэл, бэрхшээлийг илрүүлснээр, түүнд үзүүлэх дэмжлэг тодорхой болно. Суралцагч асуудал шийдвэрлэхэд ямар зөрчил, бэрхшээлтэй тулгарч байна. Үүнд, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх яагаад шаардлагатай болсон бэ? Тодорхой болсон зорилгодоо амжилттай хүрэхийн тулд, түүнд хамааралтай бүгдийг шинжин судлах шаардлага урган гарна. Энэ үе шатыг хэрэгжүүлсний үр дүнд, зорилгодоо амжилттай хүрэхийн тулд бидэнд ашиглаж болох ямар нөөц бололцоо, ямар саад байгаа вэ? гэдгээ олж харна. Ийнхүү бага боловсролын сурагчдын сэтгэн бодох чадварыг хөгжүүлэхэд лабиринт дасгал, даалгавар чухал нөлөөтэй хэмээн үзэж байна.

Дүгнэлт

Сурагчид лабиринт бодлогын хувьд тааруу гүйцэтгэсэн байгаа нь багшийн заах арга зүйтэй холбоотой хэмээн үзэж байна. Учир нь бодлогын тавилыг бүрэн ойлгосон дийлэнх сурагчид дасгалыг зөв гүйцэтгэсэн байсан. Өөрөөр хэлбэл,

сурагчдаар дасгалын хариуг шалгах, тухайн дасгалыг өөр аргаар бодох боломж бий эсэхийг эрэх зэрэг эргэн шинжлэх үйлийг орхигдуулж байгаа багшийн арга зүйтэй холбож үзсэн. Нөгөө талаас бага ангийн сурагчдын сэтгэн бодох чадварын төвшинтэй холбоотой.

Бодох аргаа хайх, сонгох үйлдлийг хангалтгүй гүйцэтгэж байгаа нь нэг талаас уг тандах судалгааг авахдаа сурагчдын шийдвэрлэх асуудалд ямар нэгэн нэмэлт тайлбар хийх, асуулт тавих зэрэг дэмжлэг туслалцаа ашиглаагүйтэй холбон үзэж болох юм. Учир нь аливаа асуудлыг шийдэх оновчтой арга стратегийг сонгоход бусадтай харилцах үйл ихээхэн нөлөө үзүүлдэг болох нь олон судалгаагаар тогтоогдсон бөгөөд ялангуяа бага ангийн сургалтад харилцаа чухал үүрэгтэй. Сурагчдын гүйцэтгэсэн бодолтоос харахад, бодлогын тавилыг буюу асуудлыг зөв ухаарч ойлгосон сурагч бодолтыг сайн гүйцэтгэж байгаагүй тогтолажиглагдсан. 4 ангийн сурагчдын шинийг сэдэж шийдвэрлэх гүйцэтгэлийн түвшин 66 хувьтай байна. Судалгаанд өгсөн даалгаврын агуулга нь суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон, боловсролын агуулгатай уялдсан бүрэн гүйцэтгэх боломжтой болох нь харагдлаа.

Хичээлд хэрэглэж байгаа бодлого, дасгал, дадлага, даалгаврын тогтолцоо, түүний уялдаа холбоо логик дарааллыг оновчтой болгон эрэмбэлж, хөтөлбөрийн агуулгатай уялдуулан, суралцагчдын шинийг сэдэж, шийдвэрлэх үйл ажиллагааг хөгжүүлэхэд ашиглах боломжтой байна.

Лабиринт дасгал даалгаварын аргад суралцсанаар хүүхэд амьдралын үйл ажиллагаанд оролцох явцдаа шинийг сэдэх, дүрслэн бодох, орон зайн төсөөлөл сэтгэхүйг нь хөгжүүлэхийн зэрэгцээ ажиглах, хэмжих, харьцуулах, жиших, байгуулах, хувиргалт хийх, загварчлах, зураг унших, шалгах зэрэг үйл ажиллагаа нь хөгжих бүтээлч чадамж төлөвших юм.

Ном зүй

- Ванчигсүрэн, Д. (2006). *“Хичээлийн технологи, хөтөлбөр, арга зүй”*. Монгол
- Жадамбаа, Б., Жонни Балтзерсен. (2008). *“Сургалтын чанар түүнийг сайжруулах арга зам”*. Улаанбаатар.
- Хөхөө, Д. (1990). *“Ээлжит хичээлийн чанар, түүнийг яаж сайжруулах вэ?”*. Улаанбаатар.
- “Мөнхийн Үсэг Групп” ХХК.
- Пүрэв, О. (2007). *“Монголын боловсрол сургалтын хүмүүжүүлэх онол, арга зүйн зарим асуудал”*. Улаанбаатар.

Survey of surveillance of the labor alternative

*Jun Xi,
Inner Mongolia Normal University*

Abstract

As a result of the technological training the criteria for the determining of the students' development level of their innovation thinking is the quality for their model creation, design, solutions resolution and its implementation. Students think that the policy of labirinte is poorly linked to the teacher's teaching methodology. On the other hand, it is related to the level of thinking of elementary students. 66% of the students in the survey completed the assignment. The problem solving was correctly identified and 18.5% of the learners were incomplete, 46.2% were incomplete, 20.1% failed, and 6.9% did not complete their ideas. The research conclusion concludes that the visual arts lesson is based on the exercise of policymaking, exercises and tasks in order to facilitate imitating, to avoid the passive form of reproduction, and whether the exercise light is correctly selected. The level of solving and resolving performance of the first four students is 66 percent. The contents of the assignment of the study have shown that it is possible to fully fulfill the specifics of the student's age and the nature of the assignment.

Key words

thinking, abstract thinking, search, creation, design and solution
